

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/71/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он</p>	<p>Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Төлбөрийн акт.....	13
4.3 Албан шаардлага	14
4.4 Зөвлөмж.....	14
Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 02. 24 № 13

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,581,398.00	1,249,108.00
33	АВЛАГА	400,000.00	165,110.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	400,000.00	165,110.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,181,398.00	1,083,998.00
35100	Түүхий эд материал	494,000.00	0
35110	Тусгай зориулалттай материал	66,500.00	0
35130	Эм боох материал	427,500.00	0
35400	Хангамжийн материал	2,687,398.00	1,083,998.00
35410	Бичиг хэргийн материал	165,000.00	0
35420	Аж ахуйн материал	2,522,398.00	1,083,998.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	123,067,346.87	254,804,134.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	123,067,346.87	254,804,134.45
39200	Биет хөрөнгө	117,667,346.87	243,504,134.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	77,251,908.00	224,939,160.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0	-16,466,088.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,900,000.00	31,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,379,999.92	-9,569,999.88
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	30,631,691.24	32,631,691.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-17,373,022.47	-21,199,395.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,672,354.58	5,672,354.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,035,584.56	-4,403,587.48
39300	Биет бус хөрөнгө	5,400,000.00	11,300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,400,000.00	11,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	126,648,744.87	256,053,242.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	369,236.00	1,199,332.36
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	369,236.00	1,199,332.36
41300	Өглөг	369,236.00	1,199,332.36
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	385,315.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	165,036.00	814,017.36
41360	Бусад өглөг	204,200.00	0
41361	Байгууллагад төлөх өглөг	204,200.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	126,279,508.87	254,853,910.09
51	Засгийн газрын хувь оролцоо	126,279,508.87	254,853,910.09
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	93,323,055.00	93,323,055.00
51200	Хуримтлагдсан үр дүн	32,956,453.87	161,530,855.09
51210	Өмнөх үеийн үр дүн	23,349,110.90	32,956,453.87
51220	Тайлант үеийн үр дүн	9,607,342.97	128,574,401.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	126,648,744.87	256,053,242.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН / төгрөгөөр /
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	171,423,186.99	322,789,260.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,870,986.99	147,907,742.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,870,986.99	147,907,742.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,425,221.26	1,896,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,509,000.00	1,896,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,916,221.26	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	10,445,765.73	146,011,742.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	154,552,200.00	174,881,518.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	150,756,200.00	170,455,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	150,756,200.00	170,455,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,796,000.00	4,426,018.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,796,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	4,426,018.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	161,815,844.02	194,214,858.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	161,815,844.02	194,214,858.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	161,479,944.02	194,128,948.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	122,069,949.00	139,513,705.00
210101	Үндсэн цалин	68,530,228.49	77,937,737.00
210102	Нэмэгдэл	43,363,721.09	49,305,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,175,999.42	12,270,468.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,281,995.00	3,501,089.82
210205	Эрүүл мэндийн даатгал	4,281,995.00	3,501,089.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,232,458.00	12,076,981.36
210301	Гэрэл, цахилгаан	1,269,493.00	1,350,500.00
210302	Түлш, халаалт	8,239,649.00	9,848,981.36
210303	Цэвэр, бохир ус	723,316.00	877,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,710,439.00	12,228,400.00
210401	Бичиг хэрэг	1,718,200.00	1,165,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,083,000.00	7,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,005,539.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	373,000.00	175,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	530,700.00	2,088,400.00
2105	Нормативт зардал	3,815,600.00	5,492,710.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,815,600.00	5,492,710.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	378,000.00	2,942,518.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	378,000.00	516,500.00
210604	Урсгал засвар	0	2,426,018.00
2107	Томилолт, зочны зардал	2,990,200.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	2,990,200.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	652,935.00	963,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	446,500.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,625.00	27,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210807	Газрын төлбөр	26,800.00	26,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,348,368.02	15,409,744.42
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,348,368.02	15,409,744.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	335,900.00	85,910.18
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	335,900.00	85,910.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	335,900.00	85,910.18
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	9,607,342.97	128,574,401.22
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	9,607,342.97	128,574,401.22

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,323,055.00	0	23,349,110.90	116,672,165.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,323,055.00	0	23,349,110.90	116,672,165.90
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	9,607,342.97	9,607,342.97
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,323,055.00	0	32,956,453.87	126,279,508.87
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	93,323,055.00	0	32,956,453.87	126,279,508.87
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,323,055.00	0	32,956,453.87	126,279,508.87
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	128,574,401.22	128,574,401.22
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	93,323,055.00	0	161,530,855.09	254,853,910.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	159,061,200.00	176,777,518.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,509,000.00	1,896,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,509,000.00	1,896,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,509,000.00	1,896,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,509,000.00	1,896,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	154,552,200.00	174,881,518.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	150,756,200.00	170,455,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	150,756,200.00	170,455,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,796,000.00	4,426,018.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,796,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	4,426,018.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	159,061,200.00	174,777,518.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,061,200.00	174,777,518.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	158,725,300.00	174,691,607.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	122,265,749.00	139,097,700.00
210101	Үндсэн цалин	67,715,828.49	77,072,000.00
210102	Нэмэгдэл	44,373,921.09	49,305,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,175,999.42	12,720,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,281,995.00	3,501,089.82
210205	Эрүүл мэндийн даатгал	4,281,995.00	3,501,089.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,250,782.00	11,428,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,269,493.00	1,350,500.00
210302	Түлш, халаалт	8,257,973.00	9,200,000.00
210303	Цэвэр, бохир ус	723,316.00	877,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,829,439.00	10,625,000.00
210401	Бичиг хэрэг	1,723,200.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,083,000.00	7,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,005,539.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	373,000.00	175,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	644,700.00	650,000.00
2105	Нормативт зардал	3,213,700.00	4,200,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,213,700.00	4,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,240,500.00	2,876,018.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	444,500.00	450,000.00
210604	Урсгал засвар	3,796,000.00	2,426,018.00
2107	Томиллолт, зочны зардал	2,990,200.00	2,000,000.00
210702	Дотоод албан томиллолт	2,990,200.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	652,935.00	963,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	446,500.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,625.00	27,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210807	Газрын төлбөр	26,800.00	26,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	335,900.00	85,910.18
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	335,900.00	85,910.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	335,900.00	85,910.18
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	2,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	2,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	2,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	2,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	2,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	-2,000,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	172,555,500.00	172,265,589.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172,555,500.00	172,265,589.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	172,555,500.00	172,265,589.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,097,700.00	139,097,700.00
210101	Үндсэн цалин	77,072,000.00	77,072,000.00
210102	Нэмэгдэл	49,305,700.00	49,305,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,720,000.00	12,720,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,649,300.00	3,501,089.82
210205	Эрүүл мэндийн даатгал	3,649,300.00	3,501,089.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,428,000.00	11,428,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,350,500.00	1,350,500.00
210302	Түлш, халаалт	9,200,000.00	9,200,000.00
210303	Цэвэр, бохир ус	877,500.00	877,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,645,500.00	10,625,000.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,800,000.00	7,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,500.00	175,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	650,000.00	650,000.00
2105	Нормативт зардал	4,200,000.00	4,200,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,200,000.00	4,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	450,000.00	450,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	450,000.00	450,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,085,000.00	963,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,000.00	27,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	26,800.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	172,555,500.00	172,278,589.82
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	170,455,500.00	170,382,589.82
310001	Улсын төсвөөс санхүүжих	170,455,500.00	170,382,589.82
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,100,000.00	1,896,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,100,000.00	1,896,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,426,018.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,426,018.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,426,018.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,426,018.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,426,018.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,426,018.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,426,018.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,426,018.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хэрэгжилтийг хангах, зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэцэгмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 139/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь хэргийн газрын үзлэгийг мэргэжлийн түвшинд хийх, үзлэгээр олдсон эд мөрийн болон бусад баримт сэлтэд мөрдөгч, прокурор, шүүхийн байгууллагын тогтоол, захирамж, хүсэлтээр гарын мөр, мөр судлал, гар бичмэл, гарын үсгийн, хуурамчаар үйлдэгдсэн бичиг баримт, мөнгөн тэмдэг зэрэгт шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлтийг гаргах, гарын хээний сан баяжуулах, галт зэвсгийн сумны хошуу, хонгиог авч санд оруулах, илрээгүй гэмт хэргийн ул мөр, хэн болох нь тогтоогдоогүй цогцсын мэдээллийн сан бүрдүүлэх, хянах, ашиглах, хэрэг илрүүлэх, нотлоход шаардлагатай бусад сан, цуглуулга, сорьц, дээжийг бий болгох хүрээлэнгийн болон орон нутаг, бүсийн төвийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд, лавлагааг оруулах үүрэг чиглэлтэй байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Учир нь тус байгууллагад дотоод аудитын нэгж байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал болох 158.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102 хувиар буюу 129.4 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь аймаг дахь цагдаагийн газраас шилжүүлэн авсан барилга, газартай холбоотой байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Тайлант онд улсын төсвөөс 170.4 сая төгрөгийн санхүүжилт, 4.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.9 сая төгрөг нийт 176.7 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж оны эцэст 0.08 сая төгрөгийн хэмнэлтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн буюу 2021 оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1.1 сая төгрөг болж 2.2 сая төгрөгөөр буурсан нь ковид-19 цар тахлын онцгой нөхцөл байдал үүсэж зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 16.3 сая төгрөгийн, үнэ хандив тусламжаар аймгийн онцгой комиссоос 0.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 17.5 сая төгрөгийн материалыг зарцуулж 1.7 сая төгрөгийн бараа материалыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл, байгууллагын даргын шийдвэрээр данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 306.4 сая төгрөг болж 155.6 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 2.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, аймаг дахь Цагдаагийн газраас 147.7 сая төгрөгийн өртөгтэй 8.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй барилга, 5.9 сая төгрөгийн газар шилжүүлэн авсан байна. Тайлант онд үндсэн хөрөнгөд 15.4 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 1.2 сая төгрөг болж 0.8 сая төгрөгөөр өссөн нь цалингийн тооцоо болон төвлөрсөн халаалтын үнийн нэмэгдэлтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 254.8 сая төгрөг болж 128.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант онд хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 161.5 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 182.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 10.1 сая төгрөгөөр бууруулж, 172.5 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь урсгал зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн шүүхийн шинжилгээ хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 172.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 170.4 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.9 сая төгрөг оруулж урсгал үйл ажиллагаанд 172.3 сая төгрөгийг зарцуулж 0.08 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 172.3 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлын зүйл ангийг 0.1 сая төгрөгөөр, бусад зардлын зүйл ангийг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 4.4 сая төгрөгийн орлогыг тайлагнасан. Нэмэлт санхүүжилтийн орлогоос 2.0 сая төгрөгийг багаж техник хэрэгсэл худалдан авахад, 2.4 сая төгрөгийг урсгал засварын зардалд тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг

санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2021 онд нийт 169.6 сая төгрөгийн 147 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн түүвэрлэн үзсэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, хариуцлага алдсан 1 албан тушаалтанд хариуцлага оногдуулах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн талаар албан бичиг нотлох баримт ирсэн байна. Аудитын гүйцэтгэх үе шатанд өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг тайлант онд давтан гаргасан байдлыг үнэлэхэд зөрчил давтагдан гараагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тээврийн хэрэгслийн ашиглалт, норм тогтоолт, нярвын бүх төрлийн тайлангийн иж бүрэн байдлыг тус тус анхаарах шаардлагатай. Тус байгууллагаас аудитын хугацаанд төсөв захирагчийн гаргасан тушаал шийдвэрийг үзэхээр ирүүлэх талаар мэдэгдэхэд нууцын зэрэглэлтэй тул үзүүлэх боломжгүй гэх тайлбар өгсөн. Шалгасан аудиторын зүгээс нууцын баталгаа гарган үзэх боломжтой талаар дурдаж байж тус баримт материалыг үзсэн бөгөөд ирсэн баримт материалд дарсан нууцын зэргийн тэмдэг байхгүй байсан. Цаашид нууцын зэрэглэлтэй гэх маягаар халхавч хийж аудитад шаардлагатай баримт материалыг гаргаж өгөхгүй байх хугацаа алдуулах явдлаа таслан зогсоох шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2.2 сая төгрөгийн алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар тайлант онд 0.3 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй, татварын тодорхойлолтоор байгууллагад төлөх 1.9 сая төгрөгийн өглөгтэй байсныг илрүүлж аудитын хугацаанд нөхөн шивүүлж анхан шатны баримтын шаардлагыг хангуулсан, өглөгийг татварын системд залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

4.3 Албан шаардлага

Тайлант оны эцэст санхүүгийн тайлангаар 0.2 сая төгрөгийн авлага 1.2 сая төгрөгийн өглөгтэй гарсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Зардлын гүйлгээг авлага өглөгөөр дамжуулалгүй шууд зардалд бичсэн, нярвын шатахууны тайлангийн сар бүрийн үлдэгдэл хасах үлдэгдэлтэй гарсан, бараа материалын тайланг заавар журмын дагуу бэлтгээгүй энэ асуудалд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т "Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг" 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний алба	4	3.6	2	2.2			1	1.4	1	